

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОСОН  
НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ АЖЛЫН ХЭСГИЙН  
ТАЙЛАН**

**Товч удирдамж:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид “журам” гэх/-ын 12.1, 12.2, 12.3, 12.4-т заасны дагуу Ажлын хэсэг нь олонхын саналаараа Улсын Их Хуралд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн талаарх тайланг энэхүү загварт нийцүүлэн бичих үүрэгтэй. Журмын 13.1-д заасны дагуу Ажлын хэсгийн тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах тул уг тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

<b>1</b>	<b>Нэр дэвшигчийн товч танилцуулга</b>  Эцэг/эхийн нэр: Навагчамба Ургийн овог: Бошго Нэр: Баасанжав Хүйс: Эмэгтэй Төрсөн он: 1974 Төрсөн газар: Улаанбаатар хот Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
<b>2</b>	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> <i>Нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний алинд нэр дэвших тухай хүсэлт гаргасан талаар бичнэ.</i> <i>Нэр дэвшигч Н.Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан.</i>
<b>Сонгон шалгаруулалт, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга</b>  Сонгон шалгаруулалтын найман үе шат бүрийг журмын Дөрөв, Тав, Зургаа, Долоо, Найм, Ес, Арав, Арван нэг, Арван хоёрт заасны дагуу хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой, ойлгомжтой бичнэ.	
<b>3</b>	<b>Нэгдүгээр үе шат</b> <i>Журмын 3.1.1-д заасны дагуу “сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i>  Хууль зүйн байнгын хороо 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоороо Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус 5 гишүүний сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй зарласан.  Байнгын хороо тогтоолдоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 17 цаг 30 минутын хооронд зарлаж, уг

	тогтоолыг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлсэн.
<b>4</b>	<p><b>Хоёрдугаар үе шат</b>  <i>Журмын 3.1.2-т заасны дагуу “нэр дэвших тухай хүсэлт гаргах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож, хүсэлт, материалыг 21 хоногийн хугацаанд хүлээн авахаар нийтэд мэдээлсэн бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Н.Баасанжав нь хүсэлт, холбогдох материалаа хугацаанд нь буюу 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр ирүүлснийг тус Байнгын хорооны ажлын алба нягтлан хүлээн авсан.</p>
<b>5</b>	<p><b>Гуравдугаар үе шат</b>  <i>Журмын 3.1.3-т заасны дагуу “Ажлын хэсэг байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт заасны дагуу 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 09 дүгээр тогтоолоороо Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт /ажлын хэсгийн ахлагч/, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргын зөвлөх Д.Батдорж, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын Өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч М.Баасанбат, Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, доктор О.Мөнхсайхан, “Шихихутаг” их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Г.Амаржаргалан нарын 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.</p>
<b>6</b>	<p><b>Дөрөвдүгээр үе шат</b>  <i>Журмын 3.1.4-т заасны дагуу “нэр дэвшигчээр бүртгэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Ажлын хэсэг 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр хуралдаж, Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д заасан нэр дэвшигчээс бүрдүүлэх материалын шаардлагыг хангасан гэж үзэн Н.Баасанжавыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчээр бүртгэсэн.</p>
<b>7</b>	<p><b>Тавдугаар үе шат</b>  <i>Журмын 3.1.5-д заасны дагуу “нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, асуулт, санал хүлээн авах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Хууль зүйн байнгын хорооны Ажлын алба нэр дэвшигч Н.Баасанжавын нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын <a href="http://www.parliament.mn">www.parliament.mn</a> цахим хуудаст 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн байршуулсан.</p>

<p><b>8</b></p>	<p><b>Зургадугаар үе шат</b>  <i>Журмын 3.1.6-д заасны дагуу “нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 10.1-д “Энэ журмын 9.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг нэр дэвшигчийг Ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж илтгэгч гишүүнийг томилно.” гэж заасны дагуу Ажлын хэсэг 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаараа нэр дэвшигч тус бүрийн илтгэгч гишүүнийг сугалаагаар тодруулсан.</p> <p>Илтгэгч гишүүн “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 10.2-т заасан ажиллагааг явуулж холбогдох мэдээллийг цуглуулсан. Тухайлбал, Нэр дэвшигчийн талаар холбогдох хүмүүстэй ярилцлага хийсэн. Ярилцлагад оролцогчид Н.Баасанжав нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар, ажлын туршлагын тухайд ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнээр ажиллахад хангалттай мэдлэг, чадвартай, аливаа асуудалд зарчимтай ханддаг бөгөөд асуудалд үндэслэл, судалгаатай хандаж, үүнийгээ тайлбарлаж ойлгуулахдаа сайн, шүүмж, санал дэвшүүлэх чадвар өндөртэй, ажлыг эхэлсэн бол эцсийг хүртэл явдаг, мөн өөрийнхөө зарчим, байр суурин дээр цөөнх болсон ч хэвээр байдаг зэрэг давуу талтай, хувь хүнийхээ хувьд ч зарчимч, ёс зүйтэй, зөв хандлагатай, шүүмж хүлээн авах чадвар сайтай гэсэн мэдээлэл илт давамгайлсан болно.</p>
<p><b>9</b></p>	<p><b>Долдугаар үе шат</b>  <i>Журмын 3.1.7-д заасны дагуу “Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Ажлын хэсэг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 11.1, 11.2-т заасны дагуу 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдөр нэр дэвшигч Н.Баасанжавтай ажлын хэсгийн ярилцлагыг зохион байгуулсан.</p>
<p><b>10</b></p>	<p><b>Наймдугаар үе шат</b>  <i>Журмын 3.1.8-д заасны дагуу “нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгох” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Ажлын хэсэг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.6-д заасны дагуу Ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналыг авсан нэр дэвшигч Н.Баасанжавыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэрийг нь дэвшүүлэхээр шийдвэрлэж, холбогдох баримт бичгийг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн.</p>
<p><b>11</b></p>	<p><b>Сонгон шалгаруулалтын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь</b>  <i>Ажлын хэсэг журмын 7.1-д заасан бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ, мөн журмын 12.4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт нь Шүүхийн тухай хууль болон энэ журмын дагуу явагдсан тухай нэгтгэн дүгнэж бичнэ.</i></p> <p>Ажлын хэсэг бүрэн эрхээ Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон журамд заасны дагуу хэрэгжүүлж, сонгон шалгаруулалтыг мөн хууль, журамд заасны дагуу зохион байгуулж</p>

	явуулсан болно.
	<p><b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан тухай үнэлгээ</b></p> <p>Нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, нэр дэвшигчийн хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээлэл, олон нийтээс ирүүлсэн асуулт, санал, нэр дэвшигчийн талаар бусад хүмүүстэй хийсэн ярилцлага, илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн ярилцлага, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, нэр дэвшигчээс болон бусад этгээдээс гаргуулан авах зэргээр цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтад тулгуурлан нэр дэвшигчид тавих шаардлагыг яагаад хамгийн сайн хангасан гэж үнэлж дүгнэсэн тухайгаа журмын 12.4.3-т заасны дагуу ойлгомжтой, тодорхой бичнэ.</p>
<b>12</b>	<p><b>Боловсрол</b></p> <p><i>Төгссөн их, дээд сургууль, коллеж, боловсролын зэрэг, төгссөн оноор нь хамгийн сүүлийнхээс нь эхлэн дараалуулж жагсааж, журмын 2.1.2, 2.2.2-т заасан шаардлагыг хангаж байгаа нь ямар мэдээлэл, нотлох баримтаар тогтоогдсон талаар бичнэ.</i></p> <p>Н.Баасанжав:</p> <p>-2002 онд ХБНГУ-ын Бавари мужийн Мюнхэн хот дахь Людвиг Максимлианы их сургуулийн хууль зүйн магистрын сургалтад суралцаж, Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.</p> <p>-1997 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн.</p> <p><i>Н.Баасанжав нь эрх зүйч мэргэжил эзэмшиж, хууль зүйн магистрын зэрэгтэй болохыг 26331 дугаар бүхий Бакалаврын диплом болон Магистрын дипломоор нотлогдож байгаа болно. /Дипломын хуулбаруудыг харна уу/.</i></p>
<b>13</b>	<p><b>Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан тухай</b></p> <p><i>Журмын 2.1.2, 2.2.2-т заасны дагуу эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</i></p> <p>Н.Баасанжав нь:</p> <p>-2007-2008 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд туслах багш /1 жил/; -2008.02 сараас 2013 оныг дуустал “Хаан банк” ХХК-д хуулийн ахлах зөвлөх /5 жил 11 сар/;</p> <p>-2013.08.30-аас өмгөөлөгч /7 жил 8 сар/.</p> <p>-2011.12 сараас “Өмгөөллийн Баасанжав консалтинг” ХХК-ийн захирал /9 жил 5 сар/ ажилласан байна.</p> <p>Нийгмийн даатгалын дэвтэр, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ, “Өмгөөллийн Баасанжав консалтинг” ХХК-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ зэрэг нотлох баримтад тулгуурлан үнэлэхэд Н.Баасанжав нь мэргэжлээрээ 25 дахь жилдээ ажиллаж байгаа тул “Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан байх” шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэж байна.</p> <p>Жич: 2001-2007 онд ХБНГУ-ын Аугсбургийн их сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимд профессор доктор Бээр /Prof Dr Behr/-ийн удирдлагад</p>

	<p>докторантурын сургалтад суралцаж, туслахаар ажилласан, 2001-2007 онд гэр бүлийн “Дусалхан компани” /тухайн үед нөхөрлөл/-д захиргаа, хуульчийн ажлыг хийж байсныг “эрх зүйч мэргэжлээр ажилласан”-д тооцоогүй болно./</p>
<p><b>14</b></p>	<p><b>Хууль зүйн өндөр мэргэшилтэй: хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай тухай</b></p> <p><i>Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</i></p> <p>Нэр дэвшигч Н.Баасанжавыг дараах үндэслэлээр “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай байх” шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэж байна. Үүнд:</p> <p>1/ Нэр дэвшигчийн талаарх ярилцлагад оролцогчид Н.Баасанжавыг ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнээр ажиллахад хангалттай мэдлэг, чадвар, ажлын туршлагатай, аливаа асуудалд зарчимтай ханддаг гэж нийтлэг байдлаар дүгнэсэн. Түүнчлэн, Ажлын хэсгийн ярилцлагын үеэр тэрээр Ажлын хэсгийн гишүүдийн асуултад үнэнчээр, мэргэжлийн өндөр түвшинд үндэслэлтэй хариултууд өгсөн. Мөн, нэр дэвшигч Н.Баасанжавын талаар тодорхойлолт өгсөн хүмүүс түүнийг “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, хуулийн практикийн арвин туршлагатай” гэж үнэлжээ.</p> <p>2/ Нэр дэвшигч Н.Баасанжав нь хууль зүйн зөвлөгөө, шүүхийн практик туршлагатай хуульч, өмгөөлөгч бөгөөд хувийн эрх зүй, ялангуяа хөдөлмөрийн эрх зүйгээр өндөр мэргэшин ажилладаг байна. Тухайлбал, түүний талаарх тодорхойлолтод “Н.Баасанжав нь хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр 2008 оноос хойш 13 дахь жилдээ ажиллахдаа нэр бүхий хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагад мэргэшиж буй чиглэлээр хууль зүйн зөвлөгөө өгч, ...ажиллаж байгаа. Хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр ... үйлчлүүлэгчийг шүүхэд төлөөлөхдөө хууль хэрэглээний чадвар сайн, гярхай, нямбай, үндэслэл сайтай, шударга ажилладаг чадварлаг өмгөөлөгч гэж дүгнэнэ.” гэж бичжээ.</p> <p>3/ Н.Баасанжав өөрийн мэргэшсэн салбар эрх зүйн хөдөлмөрийн эрх зүйн хөгжилд хувь нэмрээ оруулж идэвхтэй ажилладаг ажээ. Тухайлбал, тэрээр Монголын Хуульчдын Холбооны Хөдөлмөрийн эрх зүйн дэд хороог тэргүүлэн ажиллаж буй бөгөөд Хөдөлмөрийн тухай шинэ хуулийн төслийг боловсруулахад саналаа өгч оролцжээ. Тухайлбал, Н.Баасанжав 2017 оны Хуульчдын форумын “Хөдөлмөрийн эрх зүйн шинэчлэл, талуудын тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлага” салбар хуралдааныг удирдаж явуулж, Хөдөлмөрийн хуулийн шинэчлэлд баримтлах чухал зарчим нь “талуудын тэгш байдлыг хуулийн зохицуулалтаар хангах” гэдгийг онцолж байжээ. Мөн, 2021 оны 2 сард Монголын Хуульчдын холбооны Хөдөлмөрийн эрх зүйн дэд хорооны ажлын хүрээнд Хөдөлмөрийн тухай шинэ хуулийн төслийн үзэл баримтлал, уг хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг мэргэжлийн түвшинд танилцуулсан видео ярилцлагыг профессор Б.Уранцэцэгтэй хамтран хийсэн байна. Түүнчлэн, 2021 оны 1 сард Хөдөлмөрийн хуулийн шинэчлэлийн талаарх нийтлэл, ярилцлагыг Өдрийн сонин, Бизнесийн мэдээ сэтгүүлд хэвлүүлжээ.</p> <p>4/ Нэр дэвшигч Н.Баасанжав нь хуульчийн мэргэжлийн үйл</p>

ажиллагааны зэрэгцээ судалгааны ажлыг эрхэлж хэвлүүлж иржээ. Жишээлбэл, ХБНГУ-ын Бавари мужын Мюнхэн хотод байрлах Людвиг Максимлианы Их сургуулийн Хууль зүйн магистрын сургалтыг 1999-2002 онд суралцан “хангалтай” үнэлгээтэй төгсөхдөө ХБНГУ-ын Эрдмийн солилцооны алба (DAAD)-ын тэтгэлэгтэйгээр профессор, доктор Брунно Симмагийн удирдлагад “Дэлхийн Худалдааны Байгууллагаар маргаан шийдвэрлэх механизм” сэдвээр Магистрын ажлыг Герман хэлээр бичиж, Хууль зүйн магистрын (LL.M) зэргийг хамгаалсан. Мөн, Монгол хэл дээр дараах судалгааг дангаар болон хамтран гүйцэтгэжээ:

- 2017 онд Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа;
- 2019 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенцын 2014 оны протоколд нэгдэн орох боломжийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ;
- 2019 онд “Төрийн албанаас халсантай холбоо бүхий маргааныг захиргааны хэргийн шүүхүүд шийдвэрлэсэн байдал, анхаарах асуудлууд” сэдэвт судалгаа;
- 2018 онд Монгол Улсын дээд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн бүх сэдэвт хамаарах төрийн албан хаагчийг ажлаас халсан маргааныг шийдвэрлэх шүүхийн практик хэрхэн төлөвшиж байгааг төдийгүй Төрийн албаны тухай хуулийн зохицуулалт, өнөөгийн байдал практикт хир нийцтэй байгаа талаар давхар хөндөж, тодорхой саналуудыг дэвшүүлсэн судалгааны тайлан зэргийг хэвлүүлсэн.

Нэр дэвшигч Н.Баасанжавын бичиж хэвлүүлсэн бүтээл нь тухайн асуудалдаа дүн шинжилгээ хийсэн, хууль зүйн үндэслэл сайтай, мэргэжлийн болон жирийн иргэдийн түвшинд тохируулан ойлгомжтой, тодорхой илэрхийлэгдсэн байна.

5/Хуульч Н.Баасанжав иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгааг бэхжүүлэхийн төлөө ажиллаж иржээ. Жишээлбэл, тэрээр 2019 онд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, түүний дотор шүүх эрх мэдлийн талаарх 9 заалтыг, хожим 3 заалтыг дэмжиж хэлэлцүүлэг зохион байгуулсан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгсөн, Хуульчдын зангиагүй жагсаалыг хэсэг хуульчид болон иргэний нийгмийн идэвхтнүүдтэй хамтран хамтран зохион байгуулж байжээ. Түүнчлэн, нэр дэвшигч Н.Баасанжав 2018, 2019 оны Хуульчдын форумыг зохион байгуулах ажлын хэсгийг ахлан ажилласан бөгөөд түүний үндсэн хуралдаанаар Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл, шүүгчийн хараат бус, бие даан ажиллах хууль зүйн үндэслэлийг хөндөж, санал, зөвлөмж гаргажээ.

6/Нэр дэвшигч Н.Баасанжав хуульчийн ёс зүйгээр мэргэшин ажиллаж буй туршлагатай. Тодруулбал, 2014 оноос хойш Монголын Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны гишүүн, даргаар ажилладаг байна. Энэ хороонд ажиллахдаа 2013-2021 онд Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд явуулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд идэвх, чармайлт гарган оролцжээ. Мөн, түүний талаарх тодорхойлолтод дараах байдлаар бичжээ: “2013 оны 7-10 дугаар сард Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн төслийг ...

	<p>боловсруулахад ХБНГУ-ын мэргэжлийн үйл ажиллагааны стандартын сайн туршлагыг судалж танилцуулах, Монгол Улсын хуулийн уламжлал, практикт нийцүүлэх тал дээр идэвхтэй ажилласан хуульч бол Н.Баасанжав ...Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм нь 2013 онд батлагдаж одоо хүртэл үйлчилж байгаа бөгөөд уг дүрэмд орсон шинэлэг, дэвшилтэт зохицуулалтаас 2019 оны Өмгөөллийн тухай хууль, 2020 оны Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, 2021 оны Шүүхийн тухай хуульд тусгалаа олсон.”</p> <p>7/Н.Баасанжав нь хуульчийн өөрөө удирдах ёсны болон нийгмийн хариуцлагын хөгжилд хувь нэмэр оруулж иржээ. Тухайлбал, тэрээр хуульчийн ёс зүйн сургалтын агуулга, хөтөлбөрийг тодорхойлж, сургалтыг зохион байгуулж, сургагч багшаар ажиллаж байжээ. Мөн, 2017, 2018, 2019 онд Монголын Хуульчдын форумыг зохион байгуулах багийн бүрэлдэхүүнд орж манлайлан ажиллажээ. Уг арга хэмжээнд хамтран оролцсон хүмүүс дараах байдлаар дүгнэжээ: “Н.Баасанжав хуульчтай ... МХХ-ны нийт гишүүдийн дунд зохион байгуулдаг томоохон чуулга уулзалтын агуулга, хөтөлбөр гаргахаас эхлээд үр дүнг нь бодлого боловсруулагчдад хүргэх чухал ажлыг манлайлан гүйцэтгэж, хуульчдын олон талт оролцоо, хараат бус дуу хоолойг олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэх ажлыг гардан зохион байгуулж, багийн ажиллагааны өндөр ур чадвар, асуудалд бодитой бөгөөд шийдвэртэй хандах хандлагыг нь олж харж чадсан юм... Хуульчдын Форумын зохион байгуулалтыг зангидаж, хариуцаж ажиллах нь түүний хувьд хууль зүйн салбарын бодлогын тулгамдаж буй асуудлыг сайтар таньж мэдэх боломж олгосон гэж бодож байна.”</p>
15	<p><b>Хууль зүйн өндөр мэргэшилтэй: мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан тухай</b></p> <p><i>Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</i></p> <p>Нэр дэвшигч Н.Баасанжавын талаар хүмүүстэй ярилцлага хийхэд түүнийг асуудалд үндэслэл, судалгаатай хандаж, үүнийгээ тайлбарлаж ойлгуулахдаа сайн, шүүмж, санал дэвшүүлэх чадвар өндөртэй, ажлыг эхэлсэн бол эцсийг хүртэл явдаг, мөн өөрийнхөө зарчим, байр суурин дээр цөөнх болсон ч хэвээр байдаг зэрэг давуу талтай, хувь хүнийхээ хувьд ч зарчимч, ёс зүйтэй, зөв хандлагатай, шүүмж хүлээн авах чадвар сайтай гэсэн мэдээлэл илт давамгайлсан.</p> <p>Нэр дэвшигч Н.Баасанжавын талаарх тодорхойлолтуудад түүний талаар дараах байдлаар бичсэн байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Н.Баасанжав нь “бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан хуульч мөн,”</li> <li>• “түүний багаар ажиллах өндөр ур чадвар, бусдад хүндэтгэлтэй тэгш хандах, олон талын байр суурийг сонсож, объектив хандлагаар шийдвэр гаргадаг байдал нь түүнийг аливаа ажилд нухацтай, хараат бус ханддагийн илрэл ... харилцааны хувьд нээлттэй, зарчимч, аливаа асуудлыг зарчмын хувьд буруу гэж үзвэл түүнийгээ зоригтой илэрхийлж чаддаг, хэн нэгний нөлөөнд үл автан өөрийн итгэл үнэмшил, зарчимтай ажилладаг гэдгийн илрэл бол уу. Эдгээр эерэг чанар нь түүнийг ёс зүйтэй, зарчимч гэж үнэлж Монголын Хуульчдын</li> </ul>

	<p>Холбооны ёс зүйн хороог ахлуулж, хуульчийн ёс зүйн сэдвээр сургалт зохион байгуулах ажлыг хариуцуулсан нь гарцаагүй.” гэжээ. Дээрх болон бусад байдлаар цуглуулсан мэдээлэл, нотлох баримт, ганцаарчилсан ярилцлага болон Ажлын хэсгийн ярилцлагад үндэслэн нэр дэвшигчийг “мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага”-ыг бүрэн хангаж байна гэж дүгнэж байна.</p>
<b>16</b>	<p><b>Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй тухай</b>  <i>Журмын 2.1.3, 2.2.3-т заасны дагуу “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй” байх шаардлагыг хангаж байгааг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p><i>Монгол Улсын иргэний үнэмлэхэд “1974 төрсөн” гэж тэмдэглэгдсэн байх бөгөөд нэр дэвшигч нь 47 настай тул “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх” шаардлагыг хангаж байна.</i></p>
<b>17</b>	<p><b>Монгол Улсын иргэн мөн тухай</b>  <i>Журмын 2.1, 2.2-т заасны дагуу “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p><i>Монгол Улсын иргэнийг гэрчлэх Монгол Улсын иргэний үнэмлэхийг үндэслэн “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байна гэж дүгнэлээ.</i></p>
<b>18</b>	<p><b>Сүүлийн таван жилд улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй тухай</b>  <i>Журмын 2.1.5, 2.2.4-т заасны дагуу “сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах тушаал эрхэлж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p><i>Нэр дэвшигчээс ирүүлсэн баримт бичиг, ярилцлага, цуглуулсан мэдээлэлд үндэслэн “улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах тушаал эрхэлж байгаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж дүгнэлээ.</i></p>
<b>19</b>	<p><b>Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай</b>  <i>Журмын 2.1.6, 2.2.10-т заасны дагуу “эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж байгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p><i>Нэр дэвшигчээс ирүүлсэн баримт бичиг, ярилцлага, цуглуулсан мэдээлэлд үндэслэн “эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж дүгнэсэн болно.</i></p>
<b>20</b>	<p><b>Сахилгын шийтгэлээр халагдаж, эсхүл огцорч байсан тухай</b>  <i>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан эсэхийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p><i>Нэр дэвшигчийн талаар гаргасан тодорхойлолт, ярилцлагын мэдээлэл, нэр дэвшигчээс ирүүлсэн баримт бичигт үндэслэн нэр дэвшигч сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байгаагүй байна гэж дүгнэлээ.</i></p>
<b>21</b>	<p><b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай</b>  <i>Журмын 2.2.6, 2.3-т заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй</i></p>



	<p>буюу ажиллаж байгаагүй, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Энэ шаардлага Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид хамаарахгүй.</p>
<b>22</b>	<p><b>Шүүгчээр ажиллаж байгаагүй тухай</b>          Журмын 2.1.4, 2.2.4, 2.2.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй байх, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч шүүгчээр ажиллаж байгаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Нэр дэвшигчээс ирүүлсэн нотлох баримт болох ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох хүмүүсийн гаргасан тодорхойлолтыг үндэслэхдээ нэр дэвшигч нь шүүгчээр ажиллаж байгаагүй тул “сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж үзсэн.</p>
<b>23</b>	<p><b>Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай</b>          Шүүхийн тухай хуулийн 95.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Энэ шаардлага Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид хамаарахгүй.</p>
<b>24</b>	<p><b>Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа тухай</b>          Журмын 2.1.7-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Энэ шаардлага Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид хамаарахгүй.</p>
<b>25</b>	<p><b>Өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа тухай</b>          Журмын 2.2.8-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p>Н.Баасанжав 2013 оноос өмгөөлөгчөөр ажиллаж байгаа нь Улсын дээд шүүхээс 2013.08.30-ны өдөр олгосон Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ /Дугаар 130589/-гээр нотлогдож байгаа боловч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид “өмгөөлөгчөөр ажиллаагүй байх” шаардлага хамаарахгүй.</p>
<b>26</b>	<p><b>Прокуророор ажиллахгүй байгаа тухай</b>          Журмын 2.2.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь прокуророор ажиллахгүй байгаа гэдгийг ямар</p>

	<i>мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	<i>Энэ шаардлага Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид хамаарахгүй.</i>
<b>27</b>	<p><b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд санал болгох үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэх нь</b></p> <p><i>Ажлын хэсэг нь цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэлд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, ёс зүй, зан төлөвийг үнэлж журмын 2.1, 2.2, 2.3-т заасан харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хамгийн сайн хангаж буй гэдгийг нэгтгэн дүгнэн үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p>Нэр дэвшигч Навагчамбын Баасанжав нь Нэр дэвшигч Н.Баасанжав нь 1997 онд эрх зүйч мэргэжлээрээ төгссөнөөс хойш ХБНГУ-д суралцаж хууль зүйн магистрын зэрэг хамгаалах, судалгаа хийх зэргээр өөрийгөө хөгжүүлж иржээ. Тэрээр хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, хууль зүйн өндөр мэдлэг, чадвар эзэмшсэн, практик туршлагатай хуульч. Хуульч Н.Баасанжав нь хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, судалгаа хийх, хэлэлцүүлэг санаачлах зэргээр өөрийн мэргэшсэн салбар болох хөдөлмөрийн эрх зүйн хөгжилд хувь нэмрээ оруулдаг, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан, хариуцлагатай байдлыг хангахын төлөө чармайн тууштай ажилладаг, хуульчийн өөрөө удирдах ёсныг болон нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцдог байна.</p> <p>Иймд, Н.Баасанжав нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт заасан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдаж байгаа шаардлагуудыг бүрэн хангаж байна гэж Ажлын хэсэг дүгнэж байна.</p>

#### **Ажлын хэсгийн гишүүд**

	<b>Эцэг/эхийн нэр, өөрийн нэр</b>	<b>Гарын үсэг</b>	<b>Огноо</b>
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			

10			
11			

### Хавсралт: Тайлан гаргахад тулгуурласан баримт

- 1.Нэр дэвших тухай хүсэлт -9 хуудас;
- 2.Төрийн албан хаагчийн анкет -4 хуудас;
- 3.Монгол Улсын иргэний үнэмлэхийн хуулбар -1 хуудас;
- 4.Нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар -2 хуудас;
- 5.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, Төрийн мэдээллийн сангаас гарах лавлагаа, тодорхойлолтын нэгдсэн маягт, 2021.03.29, -3 хуудас;
- 6.Бакалаврын дипломын хуулбар, Дугаар 26331 -2 хуудас
- 7.Магистрын дипломын хуулбар, Людвиг-Максимлианы их сургуулийн Хуулийн факультет, 2001 он /орчуулгын хамт/ -2 хуудас;
- 8.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, №0209 -1 хуудас;
- 9.Хуульчдын сонгон шалгаруулалтад тэнцсэн гэрчилгээ, №0004867 -1 хуудас;
- 10.Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ, Дугаар 130589 -1 хуудас;
- 11.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, №0002203882, “Өмгөөллийн Баасанжав консалтинг” ХХК -1 хуудас;
- 12.Докторантурын сургалтад хамрагдаж байгаатай холбоотой үнэмлэх, тодорхойлолт, Аугсбургийн их сургууль, 2007 он -4 хуудас;
- 13.Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас -1 хуудас;
- 14.Тодорхойлолт, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан, 2021.03.30 -3 хуудас;
- 15.Тодорхойлолт, Хууль зүйн доктор, профессор Б.Уранцэцэг, 2021.03.31 -1 хуудас;
- 16.Тодорхойлолт, Нээлттэй нийгэм форум, Эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа, 2021.03.31 -2 хуудас;
- 17.Ажил байдлын тодорхойлолт, “Хаан банк” ХХК-ийн Хүний нөөц хариуцсан захирал Ш.Ганбямба -1 хуудас;
- 18.МУИС-ийн Хууль зүйн сургуульд 2007.07.01-ээс судлаач багшаар ажиллах болсон тухай тодорхойлолт, Дэд захирал проф.Н.Лүндэндорж, 2017.07.20 1-хуудас;

19.Хууль зүйн өндөр мэргэшилтэй талаар /жагсаалт-хүснэгт/ -5 хуудас;  
20.“Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм батлах тухай”  
Хуульчдын анхдугаар их хурлын 2013.10.05-ны өдрийн 9 дүгээр тогтоолын хуулбар  
-1 хуудас;

21.“Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороог  
байгуулж, даргыг томилох тухай” Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн  
хурлын 2013.12.14-ний өдрийн 14 дүгээр тогтоолын хуулбар -1 хуудас;

22.“Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны даргыг  
томилох тухай” Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн хурлын 2018.01.29-ний  
өдрийн 06 дугаар тогтоолын хуулбар -1 хуудас;

23.“Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүдийг батламжлах, чөлөөлөх  
тухай” Монголын Хуульчдын холбооны ээлжит дөрөвдүгээр их хурлын 2019.10.26-  
ны өдрийн 05 дугаар тогтоолын хуулбар -1 хуудас;

24.“Ажлын хэсэг байгуулах тухай” /Хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн  
төсөл боловсруулах/ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020.09.09-ний өдрийн  
А/146 дугаар тушаалын хуулбар -2 хуудас;

25.Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ,  
шаардлагын тандан судалгаа, 2017 он -56 хуудас;

26.Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай  
1930 оны 29 дүгээр конвенцын 2014 оны протоколд нэгдэн орох боломжийг  
тодорхойлох зорилгоор Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, бодлого,  
хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ, Монголын хуульчдын  
холбооны Хөдөлмөрийн эрх зүйн дэд хороо, 2019 он -68 хуудас;

27.Төрийн албан хаагчийг авилгаас сэргийлэх эрх зүйн зохицуулалт /Эрх  
зүйн боловсролыг дэмжих сангийн уралдаант комисст, МУИС-ийн ХЗДС-ийн IV  
дамжааны оюутан Н.Баасанжав/ 1997 он -25 хуудас;

28.Оюун санааны гэм хорыг нөхөн арилгах онол практикийн асуудал,  
Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл №3 /11/, 41 дэх талд, МУИС,  
1996 он -2 хуудас;

29.Бусад -14 хуудас;

30.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах  
ажлын хэсгийн гишүүн Б.Баасандоржоос нэр дэвшигч Н.Баасанжавтай хийсэн  
ярилцлагын тэмдэглэл -9 хуудас.

--оОо---